

ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА, ГАДААД
БОДЛОГО

1930-ААД ОНЫ ҮЕИЙН АЛС
ДОРНОДЫН ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА, БНМАУ

Р. Болд*

1. Зөвлөлт, Японы харилцаа, БНМАУ

XX зууны эхнээс Алс дорнодын гүрнүүд Монголыг түүхий эдийн арвин эх булаг, 1920-оод оноос улс төрийн нөлөөгөө тогтоох гол нутаг, 1930-аад онд цэргийн чухал түшиц газар хэмээн үзэх болжээ. Энэ нөхцөлд газарзүйн онцлог байрлалтай БНМАУ төдийгүй нийт монгол овогтон улс төрийн тусгаар тогтнолоо хадгалах нь амин чухал зорилт байв.

Квантуны арми Манжуурыг эзэлснээр БНМАУ мөн чанартаа гурав дахь гүрэн-Японтой «хиллэх» болсон нь ЗХУ-ыг үлэмжхэн түгшүүлжээ. 1931 оны 9-р сарын 24-нд ЗСБНХУ-ын Гадаад хэргийн Ардын комиссиарат (ГХАК) -ын орлогч Л.М Карахан БНМАУ-д суугаа төлөөлөгч А.Я Охтинд: «Япончууд Манжуурыг түрэмгийлэн эзэлж Таонанийн замаар урагшилж буй тул Баргад болон БНМАУ-ын хил дээр тэд өдөөн хатгаж болзошгүй. Цагаан гвардийнхан ч идэвхжиж магадгүй бөгөөд атаман Семенов Манжуурт ирсэн нь үүнийг гэрчилнэ. БНМАУ-ын дорнод хилд анхаарч тийшээ холбоо тогтоох, тэндээс мэдээ авах ажлыг зохицуулах явдал чухал байна» гэж мэдэгджээ¹.

Тангугийн хэлэлцээр² байгуулснаар Япон улс дэлхийн 1 дайны дараах олон улсын харилцааг бүхэлд нь зохицуулж байсан Версаль Вашингтоны гэрээнүүдийн тогтолцоо, Орос-Японы 1907 оны Портсмутын хэлэлцээрийг дангаараа зөрчсөн юм. Ингэснээр ЗХУ-д стратегийн чухал ач холбогдолтой 1726 км урт Дорнод Хятадын төмөр зам (ДХТЗ) аюулд учирсан билээ.

Квантуны арми ДХТЗ-ыг эзлэн зүүн хойд Хятадад байр сууриа бэхжүүлсний дараа л БНМАУ-д довтлох боломжтой байлаа. ЗХУ ч Японтой харилцаагаа хурцатгахаас зайлсхийж, эдийн засгаа хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө биелүүлэх, хүчээ бэхжүүлэхэд анхаарчээ. Учир нь Зөвлөлтийн Алс дорнодын хамгаалалтад тайван цагийн орон тооны 6 дивиз буюу 42 мянгахан хүн байв.

Энэ нөхцөлд ЗХУ ДХТЗ-ыг Япон-Манжгод худалдахаар шийдвэрлэн тэдэнтэй сунжирсан яриа хэлэлцээг эхэлсэн нь Квантуны арми БНМАУ-д цөмрөхийг саатуулж цаг хожсон дипломат арга хэмжээ болсон гэж дүгнэж болох юм. Гэвч сүүлд Япон ДХТЗ-ыг худалдан авч нэг ёсондоо зүүн хойд Хятадаас ЗХУ-ыг шахан гаргасан билээ.

БНМАУ-ыг нөлөөндөө оруулах гэсэн Японы цэргийнхний санал, төлөвлөгөө, мэдэгдлийг олонтаа дурдаж болно. Тухайлбал, Японы дэслэгч генерал Киокацу Сато 1931 онд хэвлүүлсэн «Монгол, Манжуурын асуудал ба эх газрын манай бодлого» номдоо; «Хэрэв Япон өөрийн гараар Манжуур, Монгол, Сибирийг ашиглахыг хүсвэл хамгийн түрүүнд ДХТЗ, Сибирийн төмөр замыг эзлэх хэрэгтэй. Тохиромжтой мөчид эдгээрийг худалдах хэлцээг Орос, Хятадын Засгийн газартай эхэлж болох юм. Монголыг ашиглахын тулд юуны өмнө Мүгдэнгээс Өргөө хүртэл төмөр зам тавих шаардлагатай... Энэхүү замыг тавьсан нөхцөлд, Жэхэ, төдийгүй Алтайн нурууг оролцуулан өргөөгөөс баруун зүгийн газар орны түүхий эдийг ашиглаж болно. Төмөр зам

*Стратегийн судалгааны төвийн нарийн бичгийн дарга.

барих энэ төлөвлөгөө хэрэгжвэл бүх Монгол, Сибирийн хэсэг Японы нөлөөнд орох болно» гэж бичжээ.

Монголыг улс төр, түүхийн үүднээс Хятадын хэсэг биш гэж үзэх хандлага Японд байсан нь түүний бодлогод бас нөлөөлж байсан болов уу. Японы элчин сайдаар Москвад сууж байсан Т.Танака 1932 онд: «Миний бодлоор Япон, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, албан ёсны харилцаа тогтоож болох юм. Арав илүү жилийн турш дотоод, гадаад байдлын хувьд тусгаар явж ирсэн улсыг тусгаар тогтносон гэж зөвшөөрөхөд гайхах зүйлгүй. Эрс дурамжхан байгаа хойд аварга замд нь саад хийхгүй бол Япон Монголыг хүлээн зөвшөөрч, Монгол түүнийг нь хүлээн авахад харшлах ямар нэгэн ноцтой шалтгаангүй гэж үзнэ» гэж хэлжээ.³

Монгол овогтон нэгдэх дэвшилт эрмэлзлийг ЗХУ, Хятадын эсрэг цэрэг-стратегийн зорилгоор ашиглахад Японы бодлого чиглэгдэж байв. Энэ нь ЗХУ төдийгүй Хятадыг болгоомжлуулж байлаа. Тухайлбал, Хятадад суугаа Зөвлөлтийн төлөөлөгч Богомоллов Москвад илгээсэн улс төрийн нэгэн илтгэлдээ Квантуны арми БНМАУ-ын эсрэг цэргийн довтолгоон хийхээр бэлтгэж буйг дурдаад: «Гадаад Монгол болон Өвөр Монголыг оролцуулан «Тусгаар тогтносон» Монгол улсыг байгуулах тохиолдолд тэд бидний эсрэг том дайнд стратегийн үлэмж давуу байдалтай болох тул Гадаад Монголын эсрэг балмад явдал үйлдэх нь Японы милитаристуудын анхаарлыг ихээхэн татаж» байгааг мэдээлжээ⁴.

1934 оноос эхлэн Сталин Монголын удирдагч нарыг дотоодын лам нарын эсрэг хүч хэрэглэхийг зөвлөн шаардаж байсан нь Японоос БНМАУ-д нөлөөлөх хүчтэй зэвсэг түүний өөгшүүлж байсан монгол туургатныг нэгтгэх хөдөлгөөн, тус хөдөлгөөнийг дэмжиж болзошгүй «5-р цуваа» нь БНМАУ-д лам нар болно гэж үзсэнтэй холбоотой бололтой.

Хятадын Засгийн газартай 1924 онд харилцаа тогтоосны дараа Монголын талаарх ЗСБНХУ-ын бодлого гол төлөв Коминтернээр дамжин хэрэгжиж байлаа. Коминтерн ч БНМАУ-ын стратегийн ач холбогдлыг судалж байв. Тухайлбал, Коминтерний дорно дахины нарийн бичгийн дарга нарын 1929 оны 1-р сарын 7-ны өдрийн зөвлөгөөний илтгэлд: «Монголын нутаг дэвсгэр нь олон улсын онцгой ач холбогдолтой юм. Тэрхүү нутаг дэвсгэрийн хэмжээ нь Англи, Герман, Францыг нийлүүлснээс их бөгөөд гэтэл хүн ам нь 800 мянгахан юм. Монгол орныг империалистууд, дэлхийн хувьсгалын дайснуудын нөлөөнд оруулчихгүйн тулд тэрхүү нутаг дэвсгэрт тогтоосон нөлөөгөө хадгалж байхад манай гол зорилт оршино. Эл зорилт нь 800 мянган малчин ардаас бүрдсэн оронд социализм байгуулах зорилтоос ч илүү чухал юм» гэж дүгнэжээ⁵.

Үл довтолцох гэрээ байгуулах Зөвлөлтийн саналыг Японы Засгийн газар 1932 онд няцаасны гадна Хятадтай үл довтолцох гэрээ байгуулах боломжгүй нь 1934 оны эхээр тодорхой болмогц ЗХУ, БНМАУ-тай харилцаагаа идэвхжүүлсэн гэж үзэх үндэстэй. 1934 оны 7-р сард Алс дорнодын олон улсын харилцаа, Хятад, Японы асуудлын туршлагатай мэргэжилтэн Л. Карахан тэргүүтэй Зөвлөлт засгийн газрын тусгай төлөөлөгчид БНМАУ-д ирсэн нь санамсаргүй хэрэг биш байв. Энэхүү айлчлалын дараа Зөвлөлт засгийн газрын урилгаар БНМАУ-ын ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд П.Гэндэн тэргүүтэй төлөөлөгчид 1934 оны 10-р сарын 21-нээс 12-р сарын 2 хүртэл ЗХУ-д айлчлан И.В.Сталин, В.М.Молотов нартай уулзжээ. Айлчлалын дүнд Зөвлөлтийн банкинд төлөх Монголын өрийг хүчингүй болгох, Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг Монголд ажиллуулах, хоёр талын худалдааг өр-

гөжүүлэх засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсны дотор хамгийн чухал нь хоёр тал улс төр, цэргийн салбарт «Цэргийн довтолгооныг урдчилан зайлуулах, түүнээс урьдчилан сэргийлэх хэрэгт бие биеэ бүх талаар дэмжих, ямар нэгэн гурав дахь этгээд ЗСБНХУ, БНМАУ руу довтолбол бие биедээ тусламж дэмжлэг өгнө»⁶ гэсэн аман хэлэлцээр байв. Хөрш орнуудтайгаа үл довтолцох гэрээ байгуулах бодлого явуулж байсан ЗХУ, БНМАУ-тай харилцан туслалцах аман хэлэлцээр байгуулснаараа ялгаатай юм. Энэ нь БНМАУ-д цэргээ оруулах боломжийг ЗХУ-д олгожээ. Алс дорнодод олон улсын байдал түгшүүртэй болсон нөхцөлд өөрийгөө хамгаалах хүчин мөхөс БНМАУ албан ёсны харилцаатай цорын ганц улс ЗХУ-ыг түшихээс өөр аргагүй байв. Ийм учраас хоёр орны аюулгүй байдлыг хангах нийтлэг эрх ашигт зохицсон дээр дурдсан хэлэлцээрийг БНМАУ сайшаан хүлээж авсан юм.

Ийнхүү 1931 оны 9-р сарын 18-наас 1934 оны 11-р сарын 27 хүртэлх Зөвлөлт, Японы харилцаанд БНМАУ шууд хөндөгдөөгүй боловч Япон Манжуурыг эзлэн Манжго улсыг байгуулснаар Алс дорнодод БНМАУ-ын стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлж, ЗХУ ч манайхтай тогтоосон харилцаагаа шинэ шатанд гаргах арга хэмжээ авч эхэлжээ.

1935 оны 1-р сарын 22-нд Квантуны арми Цахарт цөмөрсөн нь БНМАУ-ын дорнод хил дээрх Халхын сүмийн будлиантай давхацсан билээ. 2-р сарын 3-нд Зөвлөлтийн ГХАК-ын орлогч Б. Стомоняков Японы түр хамаарагч Сатог дуудан Халхын сүмийн асуудалд ЗХУ сэтгэл зовниж байгаа тул «Японы засгийн газраас холбогдох мэдээлэл авч, бодол санаатай нь танилцахыг хүсэж» байгаагаа мэдэгджээ. 2-р сарын 14-нд Сато Японы Засгийн газрын өмнөөс «Манжго нь Гадаад Монголын газар нутгийг нэг сөөм ч зөрчих бодолгүй». Японы тал эл асуудалд шууд холбогдолгүй гэсэн хариу өгчээ.

Хо-Умезу⁷, Цин-Доихара⁸ нарын хэлэлцээрээр Хойд Хятадад Япон байр сууриа бататгасан нь БНМАУ-ын зүүн өмнөд хилд түгшүүртэй байдал бий болгов. Энэ үед БНМАУ, Манжгогийн хооронд Манжуур өртөөнд эхэлсэн яриа хэлэлцээг ЗХУ хоёр талын хилийн асуудлыг зохицуулах комисс байгуулснаар хязгаарлах, гэхдээ Зөвлөлт, Японы харилцааны хүрээнд шийдвэрлэх сонирхолтой байв. Манжго-Монголын хоорондын асуудал бидэнд хамаарахгүй гэж Японы Засгийн газар мэдэгдэхийн хамт тэдгээрийн хооронд дипломат харилцаа тогтоох саналыг ЗХУ-д сөргүүлэн тавьж байлаа. Квантуны армийн штабын дарга генерал Итакаги, Хятадад сууж байсан Японы элчин сайд Аритатай Гадаад Монголын талаар ярилцахдаа: «Хэрэв Гадаад Монгол, Япон, Манжготой нэгдвэл... Алс дорнодод Зөвлөлтийн нөлөөг тулалдаангүйгээр арилгаж болно. Иймд арми нь...эхний алхам болгож Зөвлөлт Оросын бодлыг харгалзахгүйгээр Гадаад Монголыг тусгаар тогтносон улс гэж үзэн, Манжго, Гадаад Монголын хооронд хэвийн бүрэн дипломат харилцаа тогтоох хэрэгтэй» гэж дурдаж байв⁹. Манжго ч БНМАУ-тай дипломат харилцаа тогтоон, олон улсын байр сууриа бэхжүүлэх зорилготой байв. Харин БНМАУ хилийн асуудлыг зохицуулахад голлон анхаарах, гэхдээ Манжготой төлөөлөгч солилцох бодолтой байсанд ЗХУ дурамжхан байжээ. Тухайлбал, Зөвлөлтийн ГХАК-ын Токиод суугаа төлөөлөгч К. Юреневт илгээсэн нэгэн захидалд: «Японы цэрэг Монголын нутагт довтолгоогүйгээр мөргөлдөөнийг шийдвэрлэх Японы эрх баригчдын үйл ажиллагааг хөнгөвчилсэн Монголын Засгийн газрын хүлцэнгүй, аялдан дагалдсан байр суурь үргэлжилсээр байна» гэж дурджээ.¹⁰

Хятадын Засгийн газар Японтой далдуур яриа хэлцээ явуулах, Квантуны арми БНМАУ-д цөмрөх зэргээс болгоомжилсон ЗХУ,

БНМАУ-тай цэргийн харилцаагаа хуульчлан бататгах зорилгоор БНМАУ-ын удирдагчдыг урьжээ. 1935 оны 12-р сарын 1-нээс 1936 оны 1-р сарын 9 хүртэл БНМАУ-ын ерөнхий сайд П. Гэндэн тэргүүтэй төлөөлөгчид Москвад айлчлан, БНМАУ-ын гадаад, дотоод байдлын талаар И.В. Сталин, К.Е. Ворошилов, В.М. Молотов нартай санал солилцов. Сталин БНМАУ-ын Зөвхөн батлан хамгаалах асуудлыг л тэргүүнд тавьж, Монголын дотоод хэрэгт их гүрний дээрэнгүй үзлийн үүднээс оролцсон бол Гэндэн улс орныхоо нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлыг голлон тавихдаа батлан хамгаалах хэргийг орхиогүй юм.

МАХН-ын Төв Хорооны. 1936 оны 2-р сарын бүгд хурлаас Гэндэнг: «Улсыг батлан хамгаалах асуудалд анахарал тавиагүй, Японд буун өгч эх орноо эзлүүлэхийг эрмэлзсэн, лам нарыг дэмжсэн, хувьсгалын эсэргүүнүүдтэй хийх тэмцлийг сулруулсан, ЗХУ-тай тогтоосон найрамдлыг таслах оролдлого хийсэн»¹¹ хэмээн буруушааж, албан тушаалаас халсан нь Сталин, Гэндэн нарын хооронд үзэл бодлын нэлээд зөрөлдөөн байсныг харуулна. Гэвч Гэндэн Японд найр тавих бодолтой байгаагүй, харин Монгол улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх арга замын талаар Зөвлөлтийн удирдагчдаас ялгаатай байр суурьтай байжээ.

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдээс Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн илтгэлийг хэлэлцээд гаргасан тогтоолд үндэслэн БНМАУ-ын Бага хурал, Засгийн газар ЗХУ-аас цэргийн тусламж яаралтай хүсэх захидал илгээжээ. Энэ тухай тэргүүлэгчдийн хурлын 1936 оны 1-р сарын 25-ны өдрийн тогтоолд: «1... улаан цэргээс тус улсын газар нутаг дээр Моторчилсон бригад хоёр, дайран сөнөөгч онгоцны эскадриль нэг, эдгээрийг нэн даруй хурдавчлан ирүүлэхийг хүсэж явуулсугай.

2. Манай улсын дотор байгаа улаан цэргийн ангиудыг хэвээр үлдээхийг хүсэх...

3. ...Холбоот улсаас ирүүлнэ гэсэн 8 сая төгрөгнөөс цэргийн зардалд 4 сая 7 зуун мянгыг эд бараагаар, 2 сая 5 зуун мянгыг төгрөгөөр... ирүүлэхийг гуйж явуулах,

Хоёр. МАХЦ-ийн тоо хэмжээг олшруулж 17000 хүртэл нэмэгдүүлэх, дотоодыг хамгаалахын цэргийг 2500 хүртэл нэмэгдүүлэх» гэж заажээ.¹²

Үүнээс үзэхэд Монгол, Зөвлөлтийн протокол байгуулагдахаас өмнө Зөвлөлтийн цэрэг Монголд байрлаж байсан, Зөвлөлтийн цэргийг БНМАУ-д нэмж илгээх, тус улсад цэргийн тусламж үзүүлэхийг хоёр тал Москвад урьдчилан тохиролцсон нь харагдаж байна.

БНМАУ-ыг хөндсөн Зөвлөлтийн албан мэдэгдэл, дипломат баримт бичигт «Тусгаар тогтносон улс» гэж шууд хэлдэггүй байсан нөхцөлд 1936 оны 3-р сарын 1-нд Сталин АНУ-ын хэвлэлийн төлөөлөгчидтэй уулзахдаа: «Хэрвээ Япон БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтолох аваас бид БНМАУ-д ... 1921 онд тусалсан шигээ тусална» гэж БНМАУ-ыг тусгаар тогтносон улс хэмээн нэрлэсэн нь чухал ач холбогдолтой болсон юм. Үүний хамт Сталин Алс дорнодод Япон, Европт Герман гэсэн хоёр дайны голомтоос Алс дорнодын голомт нь хамгийн идэвхтэй дүрэлзэж байна гэж хэлжээ.

Сталины мэдэгдлийн дараа Литвинов Японы Элчин сайд Отад: «Зөвлөлт, Японы харилцааны хамгийн чухал асуудал нь хилийн асуудлууд Монголд дарамт шахалт үзүүлж байгаа явдал» гээд Монголд нэвтрэх оролдлогыг Зөвлөлтийн хилд учирсан аюул гэж үзэхээ мэдэгджээ.¹³

1936 оны 3-р сард Сталин, Литвиновоос гадна Молотов, ГХАК-ын орлогч Б. Стомоняков, Крестинский нар БНМАУ-ын асуудлыг хөнд-

сөн хэд хэдэн мэдэгдэл хийсний дараа 1936 оны 4-р сарын 7-нд «Известия» сонин, «Зөвлөлт, Монголын гэрээний тухайд» нэртэй өгүүлэл нийтэлж, ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд 1936 оны 3-р сарын 12-нд «Харилцан туслах протокол» байгуулсныг зарлав.

Зөвлөлтийн ГХАК-аас Токиод Юренивт: «Улаанбаатарын протокол нь БНМАУ-ын эсрэг Японы түрэмгийллийг хазаарлах... шинэ чиглэл юм. Монголыг эзлэх нь ЗХУ-тай дайнд хүргэнэ гэдэгт Япон одоо эргэлзэхгүй биз. Энэ нь сүүлийн үед Манжуур- Монголын харилцааны асуудалд Япон, Мөн Квантуны армийн штаб үлэмж хүлцэнгүй хандах болсноор нотлогдоно. Хил дээр дахин мөргөлдөөн гарч болзошгүй. Гэвч Япон бидний эсрэг дайн хийх эцсийн шийдвэр гаргах үед л Монголын эсрэг ноцтой үйлдэл гарах болов уу...» гэж мэдээлжээ.¹⁴

Монгол, Зөвлөлтийн протокол нь БНМАУ-д Квантуны арми цөмрөх тулгамдсан аюулыг зайлуулж, хамгийн гол нь БНМАУ олон улсын харилцааны эрхзүйн субъект гэдгийг дэлхий нийтэд харуулав. Зөвлөлтийн хувьд протокол нь түүний Алс дорнодын аюулгүй байдлыг бэхжүүлж, Ганьсу, Синьзянд хяналтаа тогтоох нөхцөл бүрдүүлэн, БНМАУ-ыг Японы эсрэг цэрэг стратегийнн түшиц болгон ашиглах боломж олгожээ.

Японы цэргийн гэмт хэрэгтнүүдийг шүүсэн олон улсын цэргийн шүүх хурал; «Гадаад Монгол нь Зөвлөлтийн эсрэг Японы цэргийн төлөвлөгөөнд чухал ач холбогдолтой байв. Манжуураас Байгаль нуур хүртэлх Зөвлөлтийн нутагтай хиллэдэг Монголд дайсагнагч улс цэргийн хяналтаа тогтоох нь Зөвлөлтийн нутагт бүхэлд нь, ялангуяа Зөвлөлтийн өрнөд, дорнод хэсгийг холбогч, Гадаад Монголын хилээс холгүй орших Транссибирийн төмөр замд заналхийлэх байв. ЗСБНХУ-ын адилаар Япон нь Гадаад Монголын стратегийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байлаа. Япон болон бусад аливаа орны зүгээс учирч болох үйл ажиллагааг сэрэмжлэн, 1936 онд ЗСБНХУ нь БНМАУ-тай харилцан туслах хэлэлцээр байгуулжээ» гэж дүгнэсэн байна.

Ийнхүү 1935-1936 онд Зөвлөлт, Японы харилцааны тулгамдсан асуудлын нэг нь БНМАУ-ын талаар бааримтлах бодлого байв. Монгол, Зөвлөлтийн протокол нь Алс дорнодод Японы цэрэг-стратегийн давуу байдлыг арилган, хүчний тэнцвэртэй харьцаа тогтоох боломж олгосноороо Японы дипломат бодлогод цохилт болсон Зөвлөлтийн дипломатын нэг ололт байлаа.

II. Зөвлөлт, Хятадын харилцаа, БНМАУ

Япон улс Манжуурыг түрэмгийлэн эзэлсэн нь ЗХУ, Нанжины Засгийн газар хоёрыг зөрөлдөөнөө зогсоож, дипломат харилцаагаа сэргээхэд хүргэсэн юм. Японы түрэмгийллийн эсрэг ЗХУ, Хятад хоёр нэгдвэл Алс Дорнодод дайны аюулыг хазаарлах бодит хүчин болох байв.

1932-1937 онд Хятадын талаарх Зөвлөлтийн бодлогын үндсэн агуулга нь Хятадтай үл довтолцох гэрээ байгуулахыг чармайж байсанд оршино. Уг гэрээ байгуулагдсан бол түүний хүрээнд ЗХУ БНМАУ-ыг хамгаалах асуудлаар Хятадтай зохицох бодолтой байсан бололтой. Харин Нанжины Засгийн газар ЗХУ-тай үл довтолцох гэрээ байгуулахад бэлэн биш байсан тул ЗХУ БНМАУ-тай харилцан туслах нууц протокол байгуулсан билээ. Гэвч БНМАУ-д Япон довтолох аюулыг зайлуулах нь Зөвлөлтийн Алс дорнодыг бүхэлд нь хам гаалахтай адил ач холбогдолтой байсан учир ЗХУ-аас дээрх протоколыг илээр зарлахад хүргэсний гадна Хятадын Засгийн газартай ямар нэгэн байдлаар зохицохгүйгээр эл асуудлыг шийдвэрлэж болохгүй байв. Иймд ЗХУ, Хятадын хооронд «Цэргийн нууц хэлэлцээр» байгуулах, Чан Кайшигийн саналыг ЗХУ зөвшөөрөхийн хамт «Япон ЗХУ-д

довтолбол Хятад ямар хэлбэрээр ЗХУ-д туслах бодолтой»-г Хятадаас асуусан нь дээрх зорилгыг биелүүлэхэд чиглэжээ.

1936 оны 1-р сарын 22-нд Чан Кайши: «...Японоос Монгол, Суйюань, Шаньсиг эзлэхээр завдвал ЗХУ, Хятадын Засгийн газрууд харилцан туслалцах үүрэг бүхий хэлэлцээр байгуулж болох юм» гээд энэхүү саналтай холбогдсон үүргийг Хятад авч болох юм гэж Зөвлөлтийн талд ойлгуулжээ.¹⁵

Зөвлөлт, Монголын протоколыг илээр зарлахаас өмнө ЗХУ түүний хуулбарыг Хятадын Засгийн газарт гардуулсан бөгөөд Зөвлөлтийн ГХАК-ын баримт бичигт: «... хэлэлцээр байгуулсан нь... Японы түрэмгийлэл, түүний дотор Монголын эсрэг түрэмгийлэлд ЗХУ, Хятад хоёр хэрхэн хандах талаар Нанжин, Шанхайд Н. Богомолов Хятадын төрийн нэрт зүтгэлтнүүдтэй хийсэн ярилцлагад нийцэж байгаа юм»¹⁶ гэж дурдсан зэрэг нь ЗХУ, БНМАУ-тай харилцахдаа Хятадын Засгийн газартай урьдчилан тохиролцож байсныг харуулна.

Зөвлөлт Хятадыг салгах Японы бодлого, Хятад Японыг үл ойртуулах Зөвлөлтийн бодлого хоёрын дунд Нанжины Засгийн газар гуйван дайвж байв. БНМАУ-тай протокол байгуулахыг Хятадын тал Зөвлөлтөд зөвшөөрсөн нууц тохиролцоо байна гэж Японы тал сэжиглэснээс протоколын эсрэг «шийдвэртэй арга хэмжээ» авахыг Хятадаас шаардаж байжээ. Японы шахалтаар Хятадын Засгийн газар Зөвлөлт, Монголын протоколыг эсэргүүцсэн хоёр ч нот Зөвлөлтийн талд гардуулсан байна. Зөвлөлт засгийн газар Хятадын талд өгсөн хариундаа: «ЗСБНХУ харилцан туслах протоколд гарын үсэг зурахдаа 1924 онд Бээжин хотноо байгуулсан Зөвлөлт, Хятадын хэлэлцээр цуцлагдсан зүйл огт үгүй, хүчин төгөлдөр хэвээр байгааг өгүүлсэн билээ... Зөвлөлт, Монголын хэлэлцээр нь Бээжингийн хэлэлцээрт харшлахгүй, Монгол, Хятадын ард түмний эрх ашгт нэгэн адил нийцэж байна хэ мээн эсэргүүцлийг няцаахын зэрэгцээ БНМАУ нь Хятадын бүрэн эрхийн хэсэг гэж үзсээр буйгаа нотолсон юм.»¹⁷

Монгол, Зөвлөлтийн 1936 оны протокол нь Зөвлөлт-Хятадын харилцаанд БНМАУ-ын асуудлыг дахин сөхөн тавихад хүргэсэн боловч Хятадын Засгийн газар түүнийг Японы түрэмгийллийн эсрэг нэг хүчин зүйл гэж үзсэнээр протоколыг шууд бусаар хүлээн зөвшөөрсөн болно.

1936 оны 11-р сарын 7-нд Хятадын Гадаад явдлын яамны сайд Жан Цюнь Богомоловт: «Монголын асуудлыг сөхөх нь гэж та битгий бодоорой. Надад тийм санаа ч байхгүй. Алс дорнодод Зөвлөлтийн бодлого идэвхжиж, Зөвлөлт, Монголын гэрээний хэлбэрээр байр суурь нь бэхэжсэн, ХКН-ын үйл ажиллагаа хүчтэй болсон, ийм хоёр зүйлээс япончууд болгоомжилж байна» гэж ярьжээ.¹⁸ Зөвлөлт, Монголын протоколын талаар Хятадын Засгийн газартай консенсуст хүрсэн нь Зөвлөлтийн дипломат бодлогын чухал ололт байв. Япон, Германы хооронд Коминтерний эсрэг улс төрийн гэрээ байгуулагдсантай холбогдон Зөвлөлт, Японы харилцаа 1936 оны сүүлчээс бүр ч хүйтрэв. Япон, Германы эвсэлд Хятадыг нэгтгэхгүйн тулд ЗХУ, Япон, Хятадын харилцааг тандах, тэдгээрийг үл ойртуулахад гол анхаарлаа тавих болжээ.

1937 оны 7-р сард «Марко Пологийн гүүрний хэрэг явдал»-тай залгуулан Японы цэрэг Бээжин, Тяньзиныг эзлэв. Энэ нөхцөлд 1937 оны 8-р сарын 21-нд Зөвлөлт, Хятадын хооронд үл довтолцох гэрээ байгуулагдсан нь Японы дипломат бодлогод Монгол, Зөвлөлтийн протоколоос илүү хүнд цохилт болжээ. ЗХУ-тай гэрээ байгуулснаар Хятадын Засгийн газар түүнийг Японы эсрэг дайнд татан оруулахыг чармайсан юм. Хятадын тал ЗХУ-аас Манжуурын хил дээрх цэргээ

хөдөлгөөнд оруулах, нутгийн гүнээс нэмэгдэл хүч ирүүлэх, байлдааны ажиллагаанд оролцох замаар Японы анхаарлыг татахыг шаргуу хүсэж байв.

Японы арми 8-р сард Датуныг, 9-р сард Жанчхүүг эзлэн, БНМАУ-ын өмнөд хилд ойртож, баруун хойд Хятадад цөмрөх аюул нөмрөв. Жанчхүү-Суйюаний чиглэлд Квантуны армийн оперативын бүлэг, генерал Итакагийн бүлгийн хамт 98 мянган цэрэг, 266 их буу, 282 танк, 230 онгоц бүхий хүчээр давшиж байлаа.

БНМАУ-ыг хамгаалахын зэрэгцээ Японы эсрэг дайнд Хятадыг дэмжихийн тулд ЗХУ-аас цэрэг - стратегийн дорвитой арга хэмжээ авахад хүрчээ. Ер нь ЗХУ БНМАУ-ын Өмнөд хилийг найдвартай халхлах, Хятадыг нөлөөндөө байлгахын тулд хойд, баруун хойд Хятадад цэргээ байрлуулах сонирхолтой байв. Тухайлбал, Зөвлөлт засгийн газар 1937 оны эхээр Хятадын талд «Зөвлөлт, Хятадыг Ганьсугаар холбодог цорын ганц зам харилцаанд Япон заналхийлсэн үед энэхүү зам харилцааг хамгаалдаг Хятадын цэргийн бүрэлдэхүүнд Зөвлөлтийн бие бүрэлдэхүүн бүхий нисэх хүчин, танкийн хэд хэдэн нэгтгэлийг оруулахыг Хятадын армийн командлал хүсвэл»¹⁹ холбогдох хэлэлцээр байгуулах санал тавьжээ.

Зөвлөлтийн Батлан хамгаалах Ардын комиссарын 1937 оны 9-р сарын 4-ний өдрийн тушаалаар Өвөрбайгалийн цэргийн тойргийн бүрэлдэхүүнд БНМАУ-ын нутаг дэвсгэрт 57-р онцгой корпус байгуулж, командлагчаар нь И. Коневыг томилжээ. 1937 оны 8, 9-р сард корпусын механикжсан нэгтгэлүүд БНМАУ-ын нутагт зүүн өмнөд, Өмнөд хилийн ойролцоо хүчээ хуралдуулсан байна. 1937 оны 10-р сарын байдлаар корпусын бүрэлдэхүүнд 30 мянга гаруй хүн, пулемёт 2500 орчим, их буу 540, хуягт машин 280, танк 256, автомашин 5 мянга, нисэх онгоц 107 байжээ.

ЗХУ Алс дорнодод дайнд шууд оролгүй, Хятадад туслах тохиромжтой хэлбэр нь түүнийг зэр зэвсгээр хангах, БНМАУ-д цэргийн хүчтэй бүлэглэл байгуулах явдал гэж үзэж байв. Хятад нь 1937-1939 оны сунжирсан дайнд Зөвлөлтийн зэвсгийн тусламжтайгаар Японыг үлэмжхэн сульдуулсан боловч хүнд ялагдал амссан тул ЗХУ-ыг уг дайнд орохыг ятгасаар байсан юм. 1938 оны зун Чан Кайши Зөвлөлтийн талд хандан «Эрт, орой хэзээ боловч ЗХУ, Японы эсрэг дайнд аяндаа орох тул хамгийн тохиромжтой мөч одоо л ирээд байна» гэсэн бол намар нь «Алс дорнодын хэрэг явдалд ЗХУ итэвхтэй оролцох туйлын аятай нөхцөл бүрдлээ. Учир нь бусад гүрнүүд үүнд саад хийхгүй, харин тусалж, Японы эсрэг тэмцэлд идэвхтэй оролцох болно» гэж байв.

БНМАУ нь Японы түрэмгийллийг хазаарлах цэрэг-стратегийн чухал түшиц байснаараа Хятадад шууд бус дэмжлэг болсон тул Зөвлөлт. Хятадын харилцаанд урьдын адил хурцаар тавигдсангүй. Энэ нь БНМАУ оршин тогтнох де-факто бататгав.

Зөвлөлт, Хятадын үл довтолгоо гэрээ нь Зөвлөлт, Япон, Хятад гэсэн гурвалсан харилцааг 2:1 болгон хувааж, Алс дорнод дахь хүчний харьцааг ЗХУ-д ашигтайгаар өөрчлөн Японыг ганцаардуулжээ.

III. Төгсгөл

БНМАУ-ыг эзлэх нь ЗХУ-тай тулгарахад хүргэнэ гэдгийг сайн ойлгосон Японы эрх баригчид 1930-аад оны дундаас Квантуны армийг өргөтгөн зохион байгуулж эхлэв. 1936—1939 онд Квантуны армийн дивиз 3-аас 9 болж нэмэгдсэний дотор 23-р дивиз Хайларт, БНМАУ-ын хилд хамгийн ойрхон ирж байрлав.

1939 оны 3-р сарын 10-нд ОКН-ын XVIII хуралд тавьсан илтгэлдээ И. В. Сталин: «1936 оны 3-р сард ЗХУ, БНМАУ-тай харилцан тус-

лах гэрээ, 1937 оны 8-р сард ЗХУ, Хятадтай үл довтолцох гэрээ байгуулсан юм. Бид түрэмгийлэгчдийн заналхийллээс айхгүй, Зөвлөлтийн хилийн халдашгүй байдлыг зөрчихийг оролдогч-дайн өдөөгчдөд хоёр дахин хүчтэй цохилт өгөхөд бэлэн байна» гэж мэдэгджээ²⁰

Монгол, Зөвлөлтийн протокол, Хятад, Зөвлөлтийн гэрээ нь Зөвлөлтөөр дамжин хоорондоо холбогдож, Халхын голын байлдааны ялалтыг урьдчилан хангах цэрэг-дипломатын чухал нөхцөл болсон юм.

1939 оны хавар Японы командлал Хятадын фронтын байдалд сэтгэл нэн түгшиж байжээ. Учир нь 2-р сарын сүүлийн байдлаар Япон эх газарт 35 дивиз бүхий асар их хүчийг барьж байв. Үүнээс 24 дивиз буюу 752 мянган хүн Хятадын фронтод байжээ. Гэвч стратегийн томоохон давших операц явуулахад энэ их цэрэг хангалтгүй байв. Халхын голын байлдааны үед БНМАУ-ын Өмнөд хилд байсан Зөвлөлтийн цэргийг дорнод хилд шилжүүлэхэд Хятадын фронтын байдал аятай нөлөөлсөн юм. Тухайлбал, хойд Хятадад байсан Японы 9 дивиз, 8 бригадыг Хятадын 64 явган дивиз, 13 морьт дивиз, 22 бригад өөртөө татаж байлаа.

1939 оны 5-р сарын 14-нд Японы элчин сайд С. Того Зөвлөлтийн ГХАК-аар томилогдсон В. Молотовтой ёслолын уулзалт хийх үед тэдгээрийн хооронд Халхын голын хэрэг явдалтай холбогдсон яриа гарсангүй. Гэвч тав хоногийн дараа Молотов Тогог дуудан: «5-р сарын 11-12 болон түүнээс хойш Япон-Манжгогийн ангиуд БНМАУ-ын хилийг зөрчин, Номонхан, Бүрд овоо, Дунгар овоонд байсан Монголын салбаруудыг дайрчээ. Дайралтад Япон-Манжгогийн онгоц ч оролцсон байна» гээд аливаа тэсвэр хязгаартай тул дахин ийм хэрэг өдөөхгүй байхыг шаарджээ. Того «ЗХУ дипломат асуудлаар Гадаад Монголын нэрийн өмнөөс ярих заалт Зөвлөлт, Монголын гэрээнд бий эсэх» ийг асуухад Молотов «Монголын тэсвэрийг шалгах нь шийтгэлгүй өнгөрнө гэж санах хэрэггүй. Миний мэдэгдэл Зөвлөлт, Монголын гэрээнд нийцнэ» гэж хариулжээ.²¹

1939 оны 5-р сарын 31-нд ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн чуулган дээр Молотов «БНМАУ-ын хилийг ЗХУ өөрийн хилийн адил эрс шийдвэртэй хамгаална» гэж хатуу мэдэгдсэн байна.

Зөвлөлт, Японы хувьд Халхын голын байлдаан стратегийн гэнэтийн үйл явдал байсангүй. Харин Алс дорнодод тогтсон хүчний харьцаа, цэрэг-дипломатын байдал нь Халхын голын байлдаанд ЗХУ стратегийн чанартай, Япон хязгаарлагдмал чанартай зорилтыг тус тус шийдвэрлэх нөхцөл бүрдүүлсэн байв. Японы зүгээс ЗХУ-ын эсрэг том дайн өдөөх аюулыг 1936, 1937 оны гэрээгээр нэгэнт хазаарласан ЗХУ жижиг дайн буюу Халхын голын байлдаанаар том дайны аюулыг зайлуулжээ. Япон Халхын голын байлдаанд ялагдсанаар БНМАУ-ыг түрэмгийлэх бодлоо орхисон юм. Харин ч БНМАУ-ын талаар зөвлөлт, Японы 1941 оны 4-р сарын 13-ны өдрийн тунхаглалаар Япон БНМАУ оршин тогт нох де-фактог зөвшөөрөв.

1. Монгол, Зөвлөлтийн харилцаа, I боть, 1976 308 дахь тал.

2. Тангу хотод Хойд Хятадад цэрэггүй бус байгуулах талаар Гоминданы Засгийн газар Квантуны армитай хэлэлцээр байгуулжээ.

3. «Soviet-Japanese Relations» by Tokichi Tanaka. — «Contemporary Japan, vol. 1, № 1, Tokyo, Jan. 1932, p. 22.

4. Документы Внешней политики СССР (ДВП), т. 18, с. 670.

5. «Үнэн». 1990.5 20. № 120

6. Монгол Зөвлөлтийн харилцаа, I боть, 1976, 362 дахь тал

7. 1935 оны 6-р сарын 2-нд Хятадын цэргийн яамны сайд Хо Цицинь, Хойд Хятад дахь Японы цэргийн командлагч Умезу нар Хэбэй мужаас Хятадын цэргийг гаргах хэлэлцээр байгуулжээ.

8. 1935 оны 7-р сарын 27-нд Цахар мужийн захирагч Цин, Японы генерал Доихара нар Цахараас Хятадын цэргийг гаргах хэлэлцээр байгуулжээ.
9. Mongolia in Soviet-Japanese Relations, 1933-1936, by Bridges Brian. p. 27, Nish ed. London, 1982.
10. ДВП т. 18, с. 463.
11. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд I дүгээр дэвтэр. 1966, 312 дахь тал
12. НТА, ф. 4, т. 5, х.н, 187, 81.83 дахь тал
13. ДВП. т. 19 с 275.
14. ДВП, т. 19, с. 197.
15. ДВП т. 19, с. 37.
16. ДВ. т. 19, с. 197.
17. Монгол Зөвлөлтийн харилцаа, I боть, 1976, 399 дэх тал
18. ДВП, т.19, с. 543.
- 19 ДВП, т. 20, с. 701.
20. «Год кризиса». — Документы и материалы. 1938—1939, т. 1, с. 263.
21. «Год кризиса». -Документы и материолы. 1938—1939, т. 1 с. 476.

ШИНЭ БОДЛОГО, ШИНЭ АРГА*

Г. Төмөрчулуун*

Өмнөх өгүүлэлд бид БНМАУ-ын гадаад хүрээлэлтэй холбогдсон бодлогын чанартай асуудалд голлон анхаарсан билээ. Гадаад бодлогод гадаад орчин, дэлхийн улс орнуудын бодлого, үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй боловч гадаад бодлогын тодорхой асуудлаар шийдвэр гаргах үйл явц түүнээс дутахааргүй чухал байдаг.

Манай олон улсын судлал өнөөг хүртэл гадаад бодлого судлалын зөвхөн гадаад талыг судалж ирсэн бөгөөд гадаад бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох шийдвэр гаргах үйл явцын судалгаа шинжилгээг орхигдуулж иржээ. Ийм байдал нэг талаар гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцын тухай шинжлэх ухааны салбар харьцангуй сүүлд хөгжсөнтэй холбоотой боловч¹, нөгөө талаар О. Латтимор агсны улс төр судлалын нэр томъёоны эргэлтэнд анх оруулсан «дагуул»² (зарим эрдэмтдийн «Төв», «хязгаар» улсын онолоор бол «хязгаар» улс)³ улсын тухай онолыг хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой юм.

Бие даасан гадаад бодлого явуулна гэдэг нь гадаад бодлогын гадаад, дотоод талыг цогцолбороор судлахыг шаардаж байна. Энэ асуудлаар «Өрнө, Дорно» сэтгүүлээр дамжуулан өргөн хэлэлцүүлэг явуулах нь Монгол улсын гадаад бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтойг бодож, эргэцүүлэл төдий хэдэн санаа бичив. Сэтгүүлийн зайнаас шалтгаалан энд улс орны газарзүйн байрлал, хүн ам, цаг уур, шашны уламжлал, эдийн засгийн хөгжлийн төвшин зэрэг дотоодын чанартай олон зүйл гадаад бодлогын шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлдгийг авч үзээгүй болно:

Профессор Ханс Моргентау дипломат бодлогын дөрвөн зорилтыг дараах байдлаар тодорхойлсон нь буй. Үүнд:

1. «Дипломат бодлого хүч чадавхи, бололцоондоо тохируулан өөрийн зорилтыг тодорхойлох ёстой.
2. Дипломат бодлого нөгөө улсынхаа зорилтыг тодорхойлох ёстой.

* Төгсгөл. Эхний хэсэг нь 1992. № 1-д

* Дэд эрдэмтэн.